

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНААС 2009 ОНЫ 12 ДУГААР САРД
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:

1. Улсын Их Хурал болон Байнгын хороодын хурлаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Үйлдвэрлэл технологийн паркийн тухай хууль”-ийн төслийг боловсруулан 2009 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулав. Хууль батлагдсантай холбогдуулан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”, “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын Төсвийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж, УИХ-ын 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав.
- "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн төслийг УИХ-ын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны зарим гишүүд, холбогдох яам, агентлаг, мэргэжлийн болон төрийн бус байгууллага, энэ чиглэлийн эрдэмтэн, мэргэжилтнүүд, олон улсын байгууллагатай хамтарсан ажлын хэсгийн өргөтгөсөн хуралдааныг 4 удаа зохион байгууллаа.

2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн төслийг Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар уг хуулийн төслийг дэмжсэн 80 дугаар тэмдэглэл гаргасан ба УИХ-д өргөн барих ажлын бэлтгэлийг хангаж байна.
- Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 367 дугаар тогтоолын 13 дахь заалтаар “Хэрлэнбаян-Улааны улсын тусгай хэрэгцээний нутгийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 165 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “2009 оны 6 дугаар сарын 10-наас эхлэн 2 жилийн” гэснийг “жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 1 хүртэл” гэж өөрчиллөө. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахаар отрын бүс нутагт ажиллаж орон тооны бүс зөвлөл, гэрээ байгууллаа.
- ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунай тэргүүтэй төлөөлөгчдийн 2010 оны 01 дүгээр сард БНХАУ, ХБНГУ-д хийх албан айлчлал хийх тухай асуудлыг 2009 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсантай холбогдуулан, айлчлалын бэлтгэл ажлыг хангаж байна.

3. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-д “Газар тариалан эрхлэгчдийг НӨАТ-аас чөлөөлүүлэх нэмэлт оруулах тухай хууль”-ийн төслийг Татварын ерөнхий газартай хамтран боловсруулах ажлын хэсэг байгуулж судалгааны ажил хийж байна.
- ДЭМБ, НҮБ-ын ХХААБ-ын хамтарсан Хүнсний хууль эрх зүйн хорооноос батлан гаргасан Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал стандартын 1:1 орчуулгын төслийг Стандартчилал хэмжилзүйн газрын Стандартчилалын үндэсний зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, заавал мөрдөх стандартаар батлуулав.
- Ноос, ноолуурын Техникийн хорооны хуралдаанаар ноос, ноолуурын техникийн шаардлага болон шинжилгээний аргын 13 стандартыг шинэчлэн батлуулахаар Стандартчилалын Үндэсний зөвлөлд хүргүүлээд байна.

- Ноос угаах үйлдвэрээс гарч буй бохир усны стандарт боловсруулж, Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох судалгааг хийж, стандартыг боловсруулж байна.
- Дэлхийн банкны санхүүжилтээр VSO байгууллагын Өвөрхангай аймагт хэрэгжүүлж байгаа “Ноос, ноолуурын нэмүү өртгийн гинжин сүлжээ” төслийн Зөвлөлдөх зөвлөлд ажиллан, уг төслийн үйл ажиллагааны эхний тайланг хэлэлцүүлэв.
- Модны үр сөөгний төрөл, дээж авах арга, цэвэршилт, соёлолт, амьдрах чадвар, чийг, жинг тодорхойлох арга зэрэг 8 стандартыг техникийн хорооны дэд хурал, стандартын хорооны хурлаар хэлэлцүүлж, Стандарчилалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн балуулав.
- Мод бэлтгэлийн аюулгүй ажиллагааны зааварчилга, шилмүүст болон навчит модон зүсмэл материал, бөөрөнхий модон материал, бэлдэц, согог, бөөрөнхий модон материал, эзэлхүүний таблиц, зүсмэл бүтээгдэхүүн, нэр томъёо, тодорхойлолт зэрэг 14 стандартыг стандартын дэд хороогоор хэлэлцүүлэн Үндэсний зөвлөлд батлуулахаар хүргүүлээд байна.
- “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцан, салбарын харьяа Мал эмнэлэг үржлийн газар, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, Малын эм, эмнэлгийн сорил баталгаажуулах улсын лаборатори, Мал эмнэлгийн хүрээлэн, Мал эмнэлэг, биотехнологийн сургуулиудаас санал авч Эрүүл мэндийн яаманд хүргүүлээ.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:

- “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хуваарилагдсан хөрөнгөөс орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх төслийн сонгон шалгаруулах комисс”-ын төсөл сонгон шалгаруулалтын хуралдаанаас сонгогдон арилжааны банкуудаар дамжуулан зээл авсан 38 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцлаа. Зээл авсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь жигд явагдаж байгаа бөгөөд банкнаас авсан зээлийн санхүүжилтээр хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хүрч ажиллаж байна. Ерөнхий сайд, ХХААХҮ-ийн Сайд нар зарим нэгэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай очиж танилцсан бөгөөд эдгээр аж ахуйн нэгжийн талаар NTV телевизтэй хамтран цуврал нэвтрүүлэг бэлтгэх ажил эхлээд байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч аймаг нийслэлийн Засаг дарга нартай 2010 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг 2009 оны 12 дугаар сарын 17-ны өдөр байгуулж гарын үсэг зурж баталгаажуулав.
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Махны үйлдвэрлэл, ариун цэврийг сайжруулах” техникийн туслалцааны төслийн хүрээнд Хүнсний технологийн коллеж дээр байгуулагдсан “Махны сургалтын төв”-ийн нээлтийн ажиллагааг зохион байгууллаа. Тус сургалтын төвд үйлдвэрлэсэн махан бүтээгдэхүүнийг “Монголын махны холбоо”-ны 10 жилийн ойд зориулсан үзэсгэлэнд оролцуулан сурталчилав.
- Стандартчиллын үндэсний зөвлөлийн 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд “Хэсэглэж ангилсан үхрийн мах”, “Хэсэглэж ангилсан хонь, ямааны мах” үндэсний стандартын төслүүдийг хэлэлцүүлж батлуулав.
- Цаг агаарын онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг Төв орон нутгийн ЗДТГ, Хөдөө аж ахуй эрхэлсэн байгууллагуудад хүргүүлж салхи, шуурганы үед малыг ойрын бэлчээрт хариулах, бага насны хүүхдийг малд явуулахгүй байх, малчид, ард иргэдэд шуурганд төөрөх, малтайгаа уруудах, осгох, амь насаа алдах зэрэг эрсдлээс хамгаалах арга хэмжээг авахыг анхааруулж ажиллав. Цаг агаарын энэхүү онц аюултай үзэгдлийн улмаас 100 хүн төөрч алга болсноос 98-г нь эсэн мэнд олсон, 2 хүн нас барсан байна. 23892 мал шуурганд уруудсанаас 18540 малыг олж эзэнд нь хүлээлгэн өгсөн, 5252 мал цасанд дарагдаж хорогдсон одоо 100-аад малыг хайж байна. Ховд аймгийн Үенч, Булган, Алтай сумдад цас их хэмжээгээр

орж одоогийн байдлаар зарим газраа 60см-1 м хүрснээс мал гарах, унаа машин явах боломжгүй болоод байна.

- Архангай аймгийн 3 суманд авиахимийн аргаар 55.0 мянган га талбайд, Төв аймгийн 1 суманд микробиологийн аргаар 50.0 мянган га талбайд нийт 105.0 мянган га бэлчээрийн талбайд тархсан үлийн цагаан оготнотой тэмцсэн ажлын гэрээг тус тус дүгнэж, үлдэгдэл санхүүжилт болох 241.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэв.
- Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймгуудад шинээр барьж байгуулсан худгийн ажлын орон нутгаас ирүүлсэн 6 аж ахуйн нэгжийн акт болон гүйцэтгэлийг хянаж 12 дугаар сарын 18-ны өдрийн 1/4080 тоот албан бичгээр сангийн яаманд хүргүүлж 416,7 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээлгэв.
- Газрын доорх усны геофизикийн хайгуулын ажлын техникийн тайланг 12 дугаар сарын 10-ны өдөр Дундговь, Ховд аймагт ажил гүйцэтгэсэн “Нэмэр-Интернэшнл”ХХК, Завхан аймагт ажил гүйцэтгэсэн “Ус-Амьдрал”ХХК, Хөвсгөл, Говь-Алтай аймагт ажил гүйцэтгэсэн “Оюунбадрах”ХХК-иуд хайгуулын ажлын 3 боть тайланг хүлээн авч тайланг хамгаалуулах ажлыг зохион байгуулав.
- “Монгол улсын Мастер тогооч” шалгаруулах арга хэмжээг Төрийн ордонд шинэчлэн батлагдсан журмын дагуу амжилттай зохион байгуулав. Энэ удаагийн арга хэмжээнд нийслэл, орон нутгаас 45 тогооч оролцохоор мэдүүлгээ ирүүлснээс эхний шатанд 37 тогооч тэнцэж, ур чадварын шалгаруулалтад оролцов. Эдгээрээс 18 тогооч “Монгол улсын Мастер тогооч” цолны болзлыг хангаж, ХХААХҮ-ийн Сайдаас цол тэмдгээ гардлаа.
- Архангай аймагт “Хүнсний ногоо нөөшлөх технологи” сургалтыг тус аймгийн ХХААЖДҮГ-тай хамтран зохион байгуулав. Сургалтад нийтдээ 30 гаруй хүн хамрагдаж, хүнсний ногоог хэрхэн нөөшлөх, хадгалах талаар технологийн мэдлэгтэй боллоо.
- Услалтын системийг шинээр болон сэргээн засварласан аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хянаж нийт 6.0 тэрбум төсөвлөгдснөөс гүйцэтгэлээр 5.161 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2009 онд олгов.
- Үйлдвэржилтийг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн явцын тайланг 2009 оны 12 дугаар сарын 21-ний өдөр яаман дээр Тэргүүн шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэв.
- 2009 оны 12 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Нүхт цогцолборт Ноолуурын анхдугаар зөвлөлгөөнийг Монголын ноос, ноолуурын холбоотой хамтран зохион зохион байгууллаа. Зөвлөлгөөнд хөдөө орон нутаг, үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгч, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 140 гаруй төлөөлөгчид оролцлоо. Ноолуурын боловсруулах үйлдвэрүүдийн өмнө тулгарч байгаа хүндрэлтэй асуудлууд, ноолуур бэлтгэлийн чанар, үйлдвэрлэгч, малчид, бэлтгэн нийлүүлэгчдийн ажлыг яаж холбох, түүхий эдийн биржийн асуудал, төрөөс ноолуурын талаар баримтлах бодлого зэрэг асуудлуудаар санал солилцов.
- Арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, цэвэрлэх байгууламжийг орон нутаг /нийслэл/-ийн өмчид шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэв.
- Чанарын удирдлагын тогтолцоо /ISO 9000/, Байгаль орчны удирдлагын тогтолцоо /ISO 14000/ стандартуудыг арьс ширний үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх нь сэдэвт сургалт семинарыг 2009 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, арьс ширний үйлдвэрүүдийн инженер техникийн ажилтнуудыг хамруулав.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнес эхлэл бизнес хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Говьсүмбэр аймагт “Бизнестэй танилц” хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалт,

Дархан-Уул аймгийн Шарын гол суманд “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

- Тариалангийн тухай хуулийн 15.1, “ Мөнгөн урамшууллын хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 350 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 279.291 дүгээр тушаалаар 540 гаруй аж ахуйн нэгжийн 210.0 мянган тн хүнсний буудайд 10.5 тэр бум төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэр гаргуулж, уг хөрөнгөнөөс Монгол улсын хөгжлийн сангаас уринш боловсруулалтад олгосон түлшний 3.4 тэрбум төгрөгийн зээлийг суутган үлдсэнийг оны өмнө олгох арга хэмжээ авав.
- Элеватор дээр буудай авахдаа Стандартын шаардлага хангасан буудай авах зорилт тавьсан боловч цаг үеийн байдлаас болж, стандартаас дээшхи буудайн чийг, хогт болон тарианы хольцод хорогдол тооцож авсан. ТЭДСангийн 4 салбар элеваторууд болон түрээсээр буудай хадгалуулж байгаа 5 аж ахуйн нэгжид 126.5 мянган тн буудай бохир жингээр бууснаас лабороторийн шинжилгээгээр чийг 1717.4 тн буюу 15.9 хувь, хогт хольц 705.97 тн буюу 2.56 хувь, тарианы хольц 4624.97 тн буюу 8.65 хувийн хорогдол хийж цэвэр жингээр 119.5 мянган тн буудай хүлээн авлаа. Дээрх чийгийг хатаах, хогт болон тарианы хольцоос цэвэрлэх ажиллагааг технологийн дагуу хийх талаар “ Хүнсний буудай авах, хадгалах талаар цаашид авах арга хэмжээг үүрэг болгох тухай”³⁴², “Хүнсний буудайн хаягдлыг хадгалах тухай” гүйцэтгэх захирлын 2009 оны 347 албан тоотуудыг хүргүүлж, хатаах цэвэрлэх ажиллагаа технологийн дагуу хийгдэж байна.
- Аймаг дундын отрын 5 бүс нутгаас отрын өрх, малын судалгааг 12 сарын 01-ны болон 12 сарын 25-ны байдлаар гаргаж, мэдээлэл бэлтгэлээ. 12 дугаар сарын 25 –ны байдлаар аймаг дундын отрын 5 бүс нутагт нийт 453 өрхийн 277,9 мянган мал отроор өвөлжиж байна. 12 сарын 23 -26 өдрүүдэд болсон шуурганы үеэр Багахайрханы аймаг дундын отрын бүс нутагт 50 бог 150 бог мал хорогдсон мэдээтэй байна.
- Аймаг дундын отрын бүс нутгуудаас, өнөөдрийн байдлаар тэжээлийн шаардлага захиалга ирүүлээгүй байна.Отрын мал сүргийг эрсдэлээс хамгаалах, тэжээл үйлдвэрлэх үүрэгтэй Баянчандмань дахь тэжээлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлж 10тонн тэжээлийн будаа татан авч, 5 тонн тэжээл үйлдвэрлэв.
- Аймаг дундын отрын бэлчээрийн мэдээлийн сан байгуулахад шаардлагатай материалууд, өвөлжөө, хаваржаа, хонд, бууц, худаг, агуулахын байршлын координатууд, багтаамж, даацын судалгаануудыг Хэрлэнбаян-Улаан, Аргалант, Багахайрханы аймаг дундын отрын бүс нутгуудаас хүлээн авч, эдгээр материалд тулгуурлан боловсруулалт хийж, мэдээллийн сан бүрдүүлэх, зураглал хийх ажлыг эхлүүлээд байна.
- Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Төв аймаг, Нийслэлийн Сонгинохайрхан, дүүрэгт хийгдсэн зохиомол хээлтүүлгийн ажлын үр дүнг Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран шалгалгахад хээл авалт 80.1 хувьтай байлаа. Шалгалтын дүнг нэгтгэн хэлэлцэж техникчдийг ажлын үр дүнгээр нь байр эзлүүлэв.
- Генийн санд хадгалагдаж байгаа гүн хөлдөөсөн үрийн ашиглалтын тайлан тооцоог гаргав. 2009 оны эхэнд 198873 тун үр хадгалагдаж байснаас зохиомол хээлтүүлэгт 13395, акталсан 164424, сургалтанд 6820 ашигласан байна. Импортоор авсан 7054, шинээр үйлдвэрлэсэн 4500 тун үрээр генийн санг баяжуулаж, одоогоор 25788 тун үр хадгалагдаж байна.
- Сүүний үхрийн бүртгэл мэдээлэлд хамрагдсан 2599 үнээний сүүн ашиг шимийн байдалд дүн шинжилгээ хийж, 232 иргэн, аж ахуйн нэгжид холбогдох мэдээллийг хүргүүлэв.
- Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг ХХААХҮЯ, түүний харъяа байгууллагуудад 2010 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2009 оны 365 дугаар тушаалаар батлав.

- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2009 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03/07 дугаар тушаалаар “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг батлан улмаар Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2009 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 77 дугаар тушаалаар “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, орлогыг нэмэгдүүлэх, зорилгоор тус яамтай хамтран хөтөлбөр боловсруулж Өмнөговь, Сэлэнгэ, Булган, Завхан, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар аймгийн 33 сумаас 165 өрх, хоршоо, малчдын бүлгийг сонгож тус бүрт 4.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн сургалт семинарыг зохион байгуулан ажиллаж байна

Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар

- Дэд сайд Ж.Сауле Дани Улсын Копенгаген хотод 12 дугаар сарын 06-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын бага хурал”-д оролцлоо.
- Дэд сайд Х.Золжаргал Австри Улсын Вена хотноо 12 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд зохион байгуулагдах “НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллагын Ерөнхий хуралдааны 13 дахь чуулган”-д оролцов.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн зохицуулах хорооны хурлыг зохион байгууллаа. Хурлаар уг хорооны ажиллах журмыг батлах, салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн удирдах хороодын бүтцэд өөрчлөлт оруулах, болон хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад орнуудаас авах хөнгөлөлттэй зээлийн асуудлыг хэлэлцэв.
- КР-1 төслийн шугамаар хүлээн авах буцалтгүй тусламжийн Тендерийн баримт бичгийг эцэслэн тохирох ЖИКС байгууллагын төлөөлөгч Ватанэбе тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч хамтран ажиллан, КР-1 төслийн буцалтгүй тусламж хүлээн авах Ноот бичигт гарын үсэг зурж, КР-1 хүнсний тусламжийн Тендерийн баримт бичиг болон агентын гэрээний төсөлд санал өглөө.
- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн Монголын асуудлыг хариуцсан менежер Фриц Жепсон тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч хамтран ажиллаж, ХХААХҮЯ, Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай хийсэн уулзалтуудыг ХХААХҮЯ, Сангийн яамдад зохион байгуулав.
- Азийн хөгжлийн банкнаас Өвөрхангай аймагт хэрэгжүүлж буй “Ядуу малчин өрхүүдэд зориулсан уст цэг ба Нэвтрүүлэх төв байгуулах” төслийн ажлын багийнхангай уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах талаар саналаа солилцов.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ